



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 405

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө худалдан авах,
үнийн дээд хязгаарыг тогтоох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газар, түүний харьяа хэлтсийн албан хэрэгцээнд зориулан үйл ажиллагааны давсан орлогоор, худалдан авах төлөвлөгөөний дагуу 3,000,000,000.00 (гурван тэрбум) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө худалдан авахыг зөвшөөрч, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Түмэндэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

900701

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн
705 дугаар тогтоолын хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ ҮНДСЭН ХӨРӨНГӨ,
ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР**

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	21 аймгийн мал эмнэлгийн газруудад яаралтай дуудлага үйлчилгээнд туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл худалдан авах	Ширхэг	23	966,000,000.0
2	Аймаг, нийслэлийн хяналтын цэгүүдийн шуурхай ажил үйлчилгээнд суудлын тээврийн хэрэгсэл худалдан авах	Ширхэг	7	180,000,000.0
3	Сумдын мал эмнэлгийн тасгийн шуурхай ажил үйлчилгээд мотоцикл худалдан авах	Ширхэг	331	924,000,000.0
4	Нийслэл дэх мал эмнэлгийн хяналтын цэгийн ажилчдын нөхцөлийг сайжруулах зорилгоор явуулын ажлын байр худалдан авах	Ширхэг	3	120,000,000.0
5	Аймгуудын мал эмнэлгийн газар, сумын тасгуудад компьютер, тоног төхөөрөмж худалдан авах	Ширхэг	405	460,000,000.0
6	Аймгуудын мал эмнэлгийн газар, сумын тасгуудад албан тасалгааны тавилга худалдан авах	Ширхэг	1300	350,000,000.0
Нийт дүн				3,000,000,000.0
				(гурван тэрбум)